

хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ

ТАНИЛЦУУЛГА



БИДНИЙ ТУХАЙ

Эм Ай Си Жи” ХХК нь 2009 онд бизнесийн зөвлөх үйлчилгээ эрхлэх зорилготойгоор байгуулагдсан.

2020 оноос хөрөнгийн зах зээлтэй холбоотой судалгаа, төсөл хөтөлбөрүүд дээр ажиллаж эхэлсэн.

Бид 2022 оноос “Хөрөнгө итгэмжлэн удирдах” үйлчилгээ буюу тусгай зориулалттай компанитай гэрээ байгуулж, хөрөнгийг нь хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцүүлэн удирдах үйл ажиллагааг явуулж байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид менежментийн туршлагатай тул
санхүү, менежментийн хэрэгцээг
төсөөлж зөвлөх үйлчилгээг үзүүлдэг.



Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ

- ТЗК-ийн гаргасан Баталгаат үнэт цаасыг хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн эзэмших, удирдах, хөрөнгө оруулагчдад шаардлагатай тайлан, мэдээг гаргаж өгөх,



ХБҮЦ гаргах хэлцлийн зөвлөх үйлчилгээ

- ХБҮЦ-ыг хөрөнгийн зах зээлд арилжаалахаар бэлтгэх, тусгай зориулалтын компанийг үүсгэн байгуулах, зөвшөөрөл авах зөвлөх үйлчилгээ



Бизнесийн зөвлөх үйлчилгээ

- Бизнесийн судалгаа
- Нийгэм эдийн засгийн судалгаа
- Бизнесийн төсөл боловсруулах
- Сургалт, зөвлөх үйлчилэгэ

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ЗУРАГЛАЛ



Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах эрх үүрэг бүхий этгээд байна.

ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ ТАЛУУД



Баталгаат үнэт цаас

- Баталгаат үнэт цаасыг тусгай зориулалтын компани/ТЗК/ гаргана;
- ТЗК нь хэлбэрийн хувьд ХХК байх бөгөөд баталгаат үнэт цаасыг гаргах бүрт байгуулна;
- ТЗК-ийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн бусад байгууллага байгуулж болно;
- Хөрөнгийг худалдагчийн тайлан тэнцлээс хасч, хөрөнгөтэй холбоотой шаардах эрх болон олох орлогыг тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлнэ.

- Үүсгэн байгуулагч /Банк, ОССК, ББСБ, бусад/
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч
- Үйлчилгээ үзүүлэгч
- Үнэт цаас гаргагч /ТЗК/
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч
- Хэлцэл эрхлэн гүйцэтгэгч
- Хөндлөнгийн үйлчилгээ үзүүлэгч
/хууль, аудит, андеррайтер/

Барьцаат үнэт цаас

- Барьцаат үнэт цаасыг банк, орон сууцны санхүүжилтийн компани тус тус гаргана;

ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ГЭЖ ЮУ БЭ?

ТЗК-ийн гаргасан Баталгаат үнэт цаасыг хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн эзэмших, удирдах, хөрөнгө оруулагчдад шаардлагатай тайлан, мэдээг гаргаж өгөх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, түүний хүсэл сонирхолд нийцүүлэн худалдан авах ажиллагааг хянах, амжилттай хэрэгжүүлэх ажлыг хэлнэ.



БИДНИЙ ОНЦЛОГ



- Банк санхүүгийн байгууллагуудтай уялдах санхүүгийн цогц программ ашигладаг.
- Санхүү менежмент, хууль эрхзүй, хөрөнгө удирдлагын мэргэшсэн баг ажилладаг.

ХЭЛЦЭЛ ЭРХЛЭН ГҮЙЦЭГЧИЙН ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

- Нягтлан бодох бүртгэлийн тайлан гаргах, НББОУС-ийн дагуу хөтлөх, холбогдох бичилт, бүртгэлийг бэлтгэх, холбогдох этгээдэд танилцуулах
- Татварын баримт бичгийг хугацаанд нь бэлтгэх, бүрдүүлэх, холбогдох тооцоолол, баримт бичгийг ҮЦ гаргагчид бэлтгэж өгөх, шаардлагатай татварыг төлөх;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулах
- Компанийн бүх баримт бичиг, эрх зүйн баримт бичгийг бэлтгэх, компанийн захиргааны бусад үйлчилгээг үзүүлэх
- Үйлчилгээ үзүүлэгч банкнуудтай харилцах, тэдгээрээс тайлан мэдээллийг хүлээн авах, тухайн мэдээллийг нэгтгэх, хяналт тавих, хөрөнгөтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх талаар судалгаа шинжилгээ хийх
- ТЗК-ийн тайланд аудит хийлгэх, түүнд бэлтгэх



Хөрөнгө итгэмжлэн удирдагч байгууллага нь Хэлцэл эрхлэн гүйцэтгэгчийн үүргийг гүйцэтгэж байна.

БИДНИЙ ТУРШЛАГА “БИД ХБҮЦ”

ЧИНГИС
ХААН
— ХӨРӨНГИЙН БИРЖ —

Golomt Capital®
Delivering diversity

BID BUSINESS
INVEST
DEVELOPMENT

BID-ХБҮЦ
Хөрөнгө оруулалтын төгс боломж



Товч танилцуулга

БИД ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны нээлт 2024 оны 4 дүгээр сарын 15-нд болсон.

“Хөрөнгө итгэмжлэн удирдагч” байгууллагаар манай компани ажиллаж байна.

БИДНИЙ ТУРШЛАГА “ИНВЕСКОР ӨСӨЛТ” ХБҮЦ

Монголын шилдэг ББСБ-ын
InvesCore Growth

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС



Товч танилцуулга

Монгол Улсын ТОП-100 ААН-ийн нэг Инвескор ББСБ ХК-аас “Инвескор Өсөлт” ХБҮЦ-ыг 2026 оны 1-р сард зах зээлд гаргаж байна.

Бид “Инвескор Өсөлт” ХБҮЦ-ны “Хөрөнгө итгэмжлэн удирдагч байгууллага”-аар ажиллаж байна.



Анхаарал
хандуулсанд
баярлалаа



info@micg.mn



7220-7744



Khan-Uul tower, 5th floor



micg.mn